


НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж: Нэгдүгээр хэсэг нийт 50 даалгавартай бөгөөд 1-25 дугаар даалгавар тус бүр 1 оноо, 26-41 дүгээр даалгавар тус бүр 2 оноо, 42-50 дугаар даалгавар тус бүр 3 оноотой. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариултыг сонгоорой.

1. Кофены ургамлыг хамгийн их хэмжээтэй тариалдаг улс аль нь вэ?
 A. Канад
 B. Бразил
 C. Чил
 D. Намиб
 E. Судан
2. Таримал ургамал үүссэн төвүүдийг харуулсан зурагт Баруун өмнөд Азийг хэдийн тоогоор тэмдэглэсэн бэ?



- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4
- E. 5

3. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Хуурай газар луу гүн түрж орсон далай тэнгис, нуурын усны хэсгийг гэнэ.
 A. хойг
 B. булан
 C. садраа эрэг
 D. хоолой
 E. арал
4. Монгол улсын эдийн засгийн Баруун бүсэд хамрагдах аймгууд аль нь вэ?
 A. Ховд, Булган, Увс, Говь-Алтай, Завхан
 B. Хэнтий, Дорнод, Сүхбаатар
 C. Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Төв, Дорноговь
 D. Ховд, Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Завхан
 E. Ховд, Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл
5. Аль улс нь хаант засаглалтай вэ?
 A. Дани
 B. Итали
 C. Украин
 D. Герман
 E. Польш
6. Шашин шүтлэг, шашны аялалтай холбоотойгоор хамгийн их жуулчид очдог газар аль нь вэ?
 A. Иерусалим
 B. Египт
 C. Австрали
 D. Хавай
 E. Пасхи арал
7. Далайд гарцгүй Ази тивийн улс аль нь вэ?
 A. Тайланд
 B. Иран
 C. Оман
 D. Тажикстан
 E. Пакистан


8. Цэгийн оронд байх зөв утгыг сонгоно уу. Дэлхийн соронзон орны богино хугацааны маш хүчтэй хэлбэлзэлийг гэнэ.
- A. соронзон шуурга
B. соронзон туйл
C. соронзон гаж
D. соронзон гүр
E. соронзон азимут
9. Японд ашигладаг хуванцар материал, сав суулганы үйлдвэр Филиппинд байршиж, зөвхөн бэлэн бүтээгдэхүүнээ л Япон авч байна. Үүнийг нэг төрлийн колончлол гэж үздэг. Тэгвэл энэ нь ямар төрлийн колончлол вэ?
- A. Хүн амын
B. Нутаг дэвсгэрийн
C. Экологийн
D. Далайн
E. Цаг уурын
10. Ховд гол хаанаас эх авдаг вэ?
- A. Бага Хянганы уулсаас
B. Хангайн нуруунаас
C. Хан Хэнтийн нурууны өврөөс
D. Монгол Алтайн Таван богд уулнаас
E. Хэнтийн нурууны зүүн хойд хажуугаас
11. Цэгийн оронд тохирох үгийг олно уу. тоо толгойгоор улс тэргүүлэх бөгөөд энэ нь ариун амьтан хэмээн шүтэх шашны үзэлтэй нь ихээхэн холбоотой.
- A. Үхрийн, Энэтхэг, адууг
B. Адууны, Энэтхэг, адууг
C. Хонины, Энэтхэг, хонийг
D. Хонины, Австрали, ямааг
E. Үхрийн, Энэтхэг, үхрийг
12. Хойд мөсөн далайн ай савд хамаарах гол аль нь вэ?
- A. Эг, Идэр
B. Онон, Хэрлэн
C. Тэс, Бодонч
D. Эг, Таац
E. Улз, Байдраг
13. Монгол улсын төв цэгийн солбицол аль нь вэ?
- A. х.ө $46^{\circ} 52'$ з.у $103^{\circ} 50'$
B. х.ө $56^{\circ} 28'$ з.у $101^{\circ} 47'$
C. х.ө $46^{\circ} 54'$ з.у $101^{\circ} 50'$
D. х.ө $47^{\circ} 55'$ з.у $106^{\circ} 54'$
E. х.ө $46^{\circ} 52'$ з.у $106^{\circ} 54'$
14. 1921 оноос өмнөх Монгол орны засаг захиргааны нэгжийг сонгоно уу?
- A. 4 аймаг, 2 хязгаар, бие даасан 1 хошуу
B. 4 аймаг, 3 хязгаар, бие даасан 1 хошуу
C. 4 аймаг, 4 хязгаар, бие даасан 1 хошуу
D. 4 аймаг, 1 хязгаар, бие даасан 2 хошуу
E. 4 аймаг, 2 хязгаар, бие даасан 2 хошуу
15. Дараах нууруудаас аль нь галт уулын гаралтай вэ?
- A. Толбо, Даян
B. Увс, Хяргас
C. Хөвсгөл, Хөх нуур
D. Тэрхийн цагаан, Уран тогоо
E. Толбо, Хяргас
16. 1870-1883 онд Монголд 4 удаа ирсэн Оросын жуулчин “Монгол ба Тангадын орон” гэсэн ном бичсэн байдаг. Энэ жуулчны нэр хэн бэ?
- A. Н.М.Пржевальский
B. Марко Поло
C. П.К.Козлов
D. С.Н.Потанин
E. Э.М.Мурзаев

25. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд үзэгдлийн тасралтгүй үргэлжилсэн буюу өөрчлөгдсөн шинж байдлыг дүрслэхэд хэрэглэдэг аргыг гэнэ.
- цэгийн арга
 - талбайн арга
 - ижил шугамын арга
 - тэмдэгтийн арга
 - хөдөлгөөнт шугамын арга
26. Хүн амын нягтшилтыг хэрхэн тооцоолох вэ?
- Нийт хүн амыг нийт нутаг дэвсгэрт нь харьцуулна
 - Нийт нутаг дэвсгэрийг нийт хүн амд нь харьцуулна
 - Нэгж талбайд ногдох 1000 хүний тоо
 - 1000 хүнд ногдох нэгж талбай
 - Нийт нутаг дэвсгэрийг нийт хүн амд нь үржүүлнэ
27. Дэлхийн улс орнууд Хүн амын чанарын үзүүлэлтийг тодорхойлохдоо дор өгөгдсөн цогц ойлголтоор илэрхийлдэг бөгөөд дараах бүдүүвчийн хоосон нүдэнд тохирох хариултыг сонгоно уу.



- улс төрийн
- эрүүл мэндийн
- соёлын
- хоол тэжээлийн
- ажлын байрны

28. Хөрсний зүсэлтийн зурагт О үсгээр юуг тэмдэглэсэн бэ?



- Дээд хөрс
- Доод хөрс
- Гадарга
- Эх чулуулаг
- Угаagdлын үе

29. Хэнтий аймаг дахь аялал жуулчлалын үзмэрүүд аль нь вэ?


- A. Хар хорин, Өгчлөгчийн хэрэм, Рашаан хад, Отгонтэнгэр уул, Хүйсийн найман нуур
- B. Хөвсгөл нуур, Даян дээрхийн агуй, Улаан цутгалан, Талын агуй, Амарбаясгалант хийд
- C. Түвхэн хийд, Талын агуй, Ёлын ам, Өгчлөгчийн хэрэм, Хар зүрхний хөх нуур
- D. Хамрын хийд, Даян дээрхийн агуй, Рашаан хад, Амарбаясгалант хийд
- E. Рашаан хад, Өгчлөгчийн хэрэм, Хар зүрхний хөх нуур, Балдан бэрээвэн хийд, Чингэсийн хэрмэн зам

30. Зурагт үзүүлсэн рельефийн хэлбэр геоморфологийн ямар үйл явцын үр дүнд үүссэн бэ?



- A. Салхины үйл ажиллагаагаар
- B. Урсгал усны үйл ажиллагаагаар
- C. Галт уулын дэлбэрэлтээр
- D. Мөсөн голын үйл ажиллагаагаар
- E. Газар хөдлөлтөөр

31. Хүн амын нас хүйсийн суваргын 10- 14 насны хүн амын тоо бага байхад нөлөөлсөн гол хүчин зүйл аль нь вэ?




- A. Аж үйлдвэрийн хувьсал
- B. Дэлхийн хоёрдугаар дайн
- C. 60000 орчим казах иргэд Казахстан улсруу шилжсэн
- D. Зуд болсон
- E. Ган болсон

32. Сарлагийн аж ахуй эрхлэхэд тохиромжтой мал аж ахуйн муж аль нь вэ?

- A. Алтай- Хан хөхийн уулт хээрийн муж
- B. Хангай- Хөвсгөл- Хэнтийн ойт хээрийн муж
- C. Төв ба Дорнодын тал хээрийн муж
- D. Өмнөговийн муж
- E. Хянганы уулс

33. Б.П.Алисовын ангилалаар хийгдсэн Евразийн уур амьсгалын бүсийн зурагт 1- ийн тоогоор ямар бүсийг тэмдэглэсэн вэ?



- A. Тропикийн
- B. Экватор орчмын
- C. Сэрүүн
- D. Туйл орчмын
- E. Туйлын

34. Арлуудыг орших далайтай нь зөв тохируулна уу.

- 1) Азорын арлууд
- 2) Сейшелийн арлууд
- 3) Каролины арлууд
- 4) Шинэ газрын арал

- a) Умард мөсөн далай
- b) Энэтхэгийн далай
- c) Номхон далай
- d) Атлантын далай

- A. 1a, 2c, 3d, 4b
- B. 1c, 2d, 3a, 4b
- C. 1a, 2b, 3c, 4d
- D. 1d, 2b, 3c, 4a
- E. 1b, 2a, 3d, 4c

35. 4 цагийн хугацаанд дэлхий тэнхлэгээ хэдэн градусаар эргэх вэ?

- A. 60°
- B. 15°
- C. 30°
- D. 75°
- E. 45°

36. Төмрийн хүдрийн нөөц 400 тэрбум орчим тонн бөгөөд талаас илүү хувь нь нутаг дэвсгэрт бий.

- A. хөгжингүй орнуудын
- B. хөгжиж буй орнуудын
- C. Африкийн
- D. Австралийн
- E. Хойд Америкийн

37. 2007 онд 15 аймгийн 88 сум, нийслэлийн 7 дүүргийн нутаг дэвсгэрт 216 удаа удаа түймэр гарсны улмаас ойн 512231 га талбай, хээрийн 822954 га талбай шатсан. Нийт хэдэн км^2 газар түймэрт өртсөн бэ?

- A. 1335185 км^2
- B. 1235185 га
- C. $123518,5 \text{ км}^2$
- D. $12351,85 \text{ км}^2$
- E. $13351,85 \text{ км}^2$

38. Төв ба зүүн Азийн орнуудын экспортын гол бүтээгдэхүүн юу вэ?

- A. Газрын тос, арьс ширэн эдлэл
- B. Машин, цахилгаан- радио техник, химийн үйлдвэрлэл
- C. Хөвөн, каучук, машин
- D. Төмрийн хүдэр, үнэт мод
- E. Бэлэн хувцас, машин, газрын тос

39. Байгалийн унаган төрхийг хамгаалах төрөл бүрийн арга зам байдаг. Манай улсын тусгай хамгаалалттай 61 газар байдаг. Эдгээрээс доор өгөгдсөн газруудыг орших аймагтай нь харгалзуулснаас зөвийг нь сонгоно уу.

- | | |
|-------------------------------|----------------|
| 1) Хасагт хайрхан уул | a) Өмнөговь |
| 2) Говийн бага дархан газар А | b) Сүхбаатар |
| 3) Лхачинвандад | c) Дорнод |
| 4) Яхь нуур | d) Говь- Алтай |
- A. 1a, 2b, 3c, 4d
 B. 1b, 2d, 3c, 4a
 C. 1b, 2a, 3d, 4c
 D. 1a, 2b, 3d, 4c
 E. 1d, 2a, 3b, 4c

40. Хүснэгтэнд өгөгдсөн мэдээллийн зөв тохируулна уу.

| Тэнгисийн нэр | дугаар | Далайн нэр | Тэмдэглэгээ |
|---------------|--------|-------------|-------------|
| Улаан | 1 | Номхон | a |
| Балтын | 2 | Умард мөсөн | b |
| Шар | 3 | Атлантын | c |
| Карын | 4 | Энэтхэгийн | d |

- A. 1c, 2a, 3d, 4b
 B. 1d, 2b, 3a, 4c
 C. 1b, 2a, 3c, 4d
 D. 1d, 2c, 3a, 4b
 E. 1b, 2d, 3c, 4a


41. Хүн ам нь 100 саяас дээш, газар нутгийн хэмжээ нь 1 сая км²- аас их улс орнууд аль нь вэ?

- A. Австрали, Канад, Хятад, Энэтхэг, ОХУ
 B. Бразил, Япон, АНУ, ОХУ, Энэтхэг
 C. Саудын Араб, Алжир, АНУ, Хятад, ОХУ
 D. Аргентин, АНУ, ОХУ, Хятад, Энэтхэг
 E. Бразил, ОХУ, Хятад, Энэтхэг, АНУ

42. Энэ нь бүхэлдээ хөгжиж буй бүс нутаг бөгөөд байгалийн баялаг ихтэй ч төрийн бодлого, олон улсын худалдааны дэглэм ба геополитик, хүний эрхийн зөрчил, колончлолын сөрөг үр дагавар, боловсролын түвшин бага. Эдийн засгийн гол салбар нь хөдөө аж ахуй, алт, алмаз олборлодог бол энэ аль бүс нутаг вэ?

- | | |
|-----------------------------------|------------------------|
| A. Хойд Африк ба Баруун өмнөд Ази | D. Оросын холбооны улс |
| B. Сахараас урагших Африк | E. Өмнөд Ази |
| C. Хятад | |

43. Уругвай улсын уур амьсгал нь газар тариалан эрхлэхэд тааламжтай бөгөөд, уур амьсгалд нь нөлөөлж буй далайн урсгалыг зурагт хэдийн тоогоор тэмдэглэсэн бэ?




- A. 1
 B. 4
 C. 3
 D. 8
 E. 5

44. Агаар бохирдуулагч элемент ба түүний эх үүсвэрийг зөв харгалзуулна уу.

- | | |
|--------------------------|---|
| 1) Метан | a) Амьсгал, түлшний шаталт, үйлдвэр |
| 2) Метан бус гидрокарбон | b) Түлшний шаталт, үйлдвэр |
| 3) Угаарын хий | c) Цагаан будааны тариалан, хөрсний гулсалт, амьтан |
| 4) Нүүрсхүчлийн хий | d) Бүрэн бус шаталт, биомассын шаталт |


- A. 1c, 2b, 3d, 4a
 B. 1d, 2a, 3b, 4c
 C. 1b, 2c, 3d, 4a
 D. 1c, 2d, 3b, 4a
 E. 1a, 2d, 3c, 4b

45. Дараах зурагт тохирох хамгийн оновчтой үг аль нь вэ?




- A. Хот
 B. Хөдөө
 C. Дэд бүтэц
 D. Барилга
 E. Агломераци

46. Дараах зурагт хоёрдогч үйлдвэрлэлийн салбарт ажиллагчдын хувь хэмжээгээр хамгийн их улс хэдийн тоогоор тэмдэглэгдсэн бэ?




- A. 1
 B. 2
 C. 3
 D. 4
 E. 5

47. Гурвын тоогоор хотын ямар функцийг тэмдэглэсэн бэ?




- A. Төвийн бизнес дүүрэг
- B. Орлого багатай иргэдийн орон сууц
- C. Дундаж орлоготой иргэдийн хороолол
- D. Баячуудын хороолол
- E. Хүнд аж үйлдвэр

48. А цэгт сафари аялал хийсэн жуулчин Б цэгт очин арслан, дэлт чоно, матар, анааш зэрэг амьдын зураг авах аялал хийсэн. Жуулчин байгалийн ямар бүсээс ямар бүсэд очсон бэ?




- A. Саванны бүсээс цөлийн бүс рүү
- B. Саванны бүсээс хатуу навчит ой , бутлаг ургамлын бүс рүү
- C. Экваторын чийглэг ойгоос саванны бүс рүү
- D. Экваторын чийглэг ойгоос цөлийн бүс рүү
- E. Цөлийн бүсээс экваторын чийглэг ойн бүс рүү

49. 2007 он гарсаар Өвөрхангай аймагт 3, Архангай аймагт 2, Дундговь аймагт 1, Хөвсгөл аймагт 1 удаа, нийт 7 удаа аянга буусны улмаас 3 хүн нас барж, 6 хүн түлэгдэж, 97 толгой мал аянгад өртжээ. Монгол улсын газрын зурагт эдгээр аймгуудыг хэдийн тоогоор тэмдэглэсэн вэ?



- A. 8, 5, 6, 11
- B. 13, 8, 5, 12
- C. 12, 11, 6, 15
- D. 8, 9, 10, 12
- E. 1, 3, 6, 12

50. А цэг дээр агаарын температур $-5,5^{\circ}\text{C}$ байсан бол Б цэг дээр хэдэн хэм байхыг бодож олно уу?



- A. $1,3^{\circ}\text{C}$
- B. $-2,6^{\circ}\text{C}$
- C. $-1,3^{\circ}\text{C}$
- D. $1,5^{\circ}\text{C}$
- E. $-1,8^{\circ}\text{C}$

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТООЦООЛОХ ДААЛГАВАР

Санамж: Хоёрдугаар хэсэг нь тус бүр 4 оноотой 4 даалгавраас бүрдэнэ. Даалгаврын хариуг хариултын хуудсанд дараах байдлаар тэмдэглэнэ үү. *Жишээлбэл:*

- Эцсийн хариу 342 гэж гарсан бол a-3, b-4, c-2 гэж бөглөнө.
- Нарны өндөр олох бодлогын хариу $75^{\circ}28'$ гэж гарсан гэж үзвэл a-7, b-5, c-2, d-8 гэж бөглөнө.

2.1. Улаанбаатар хот х.ө $47^{\circ}55'$, з.у 107° оршдог. Тэгвэл 9 дүгээр сарын 23-нд үдийн нарны өндөр хэдэн градус, хэдэн минут байхыг бодож олно уу.

2.2. 1:2500000 масштабтай зураг дээр 5 см зурагдсан зай 1:100000 масштабтай зураг дээр хэдэн см зурагдах вэ?

2.3. з.у 17° - т орших нутагт өдрийн 12 цаг болж байхад Улаанбаатар хотод хэдэн цаг болж байх вэ?

2.4. Тухайн голын өргөн 25 м, голын хамгийн гүн хэсэг нь 3 м бол голын хөндлөн огтлолын талбай хэдэн м^2 байх вэ?